Улаанбаатар хотын хүн амын амны хөндийн зарим үзүүлэлтийг судалсан дүн

Б.Баярмаа[1], Б.Оюунцэцэг[1]

[1]АШУҮИС, НАСС, ХНАСУС-ийн тэнхим
Цахим хаяг: Bayarmaa1725@gmail.com, Утас: 99088167

Түлхүүр үг:

Шүд цоорох өвчин
Шүд цоорох өвчний тархалт
Шүд цоорох өвчний эрчим
Амны эрүүл ахуй

Товч утга: Шүд цоорох өвчин нь дэлхийн улс орны хөгжлийн чиг хандлагыг дагаад хүн амын дунд өндөр тархалттай тохиолддог халдварт өвчин юм. Сүүлийн жилүүдийн судалгааны үр дүнгүүдээс харахад дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшин, нийгэм эдийн засгийн хүчин зүйл, хүн амын боловсрол, амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг дадал зэргээс хамааран шүд цоорох өвчний тархалт харилцан адилгүй байна. ДЭМБ-ын зөвлөмж, шалгуур үзүүлэлтийн дагуу дэлхийн бусад улс орны үзүүлэлтүүдтэй харьцуулах, мэдээллийн сан бүрдүүлэхийн тулд насны бүлгүүдийн амны хөндийн байдлыг судлан тогтоох нь судалгааг хийх үндэслэл боллоо. Энэхүү судалгааг АШУҮИС-ийн НАСС-ийн ХНАСУС-ийн тэнхимийн төсөлт ажлын хүрээнд 2015-2016 онуудад хийгдсэн Улаанбаатар хотын 5, 12, 35-44, 65-74 насны бүлгүүдийн нийт 1936 хүний амны хөндийн үзлэгийн картыг ашиглан шүд цоорох өвчний тархалт, эрчим, амны хөндийн эрүүл ахуйн үзүүлэлтийг судалсан болно. Судалгаанд хамрагдагсадын ШЦӨ-ний тархалт 5, 12, 35-44, 65-74 насны бүлгүүдэд 90.1%, 81.4%, 98.2%, 99.8%, ШЦӨ-ний эрчмийн үзүүлэлт 6.9±0.20 цла/ш, 2.5±0.10 ЦЛА/ш, 12.1±0.30 ЦЛА/ш, 24.6±0.33 ЦЛА/ш тус тус байлаа. Амны эрүүл ахуйн байдал насны бүлгүүдэд 47.5%, 46.1%, 45.7% 25.6% нь тус тус хангалтгүй үзүүлэлттэй байлаа.

Үндэслэл: Ам нь хүний биеийн гадаад орчинтой харьцах хэсгийн нэг бөгөөд бие махбодод физиологийн хувьд хамгийн цогц, чухал ач холбогдолтой хэсэг юм. Ам нь хоол боловсруулалтын эхний үе шат явагддаг, хөхөх, зажлах, залгих, ярих үйл болон амтлах, дулааны хэм, бүтэц найрлагыг таних зэрэг мэдрэхүйн үйл ажиллагааны бүтцүүдээр баялаг амьдралын чухал эрхтэн. Амны хөндийн болон бие махбодын эрүүл мэнд хоорондоо салшгүй хамааралтай бөгөөд амны хөндий эрүүл байх нь хүний гадаад төрх, өөртөө итгэлтэй байдал, амьдралын зөв хэвшилд чухал нөлөө үзүүлдэг.[1] Дэлхий даяар 3.9 тэрбум хүн амны хөндийн өвчлөлтэй байна.[2] Амны хөндийн өвчлөлүүдийн ихэнх нь урьдчилан сэргийлэх боломжтой тул эрт оношлогдсон тохиолдолд эмчлэгдэх бүрэн боломжтой байдаг. Хөгжиж буй орнуудад хотжилт эрчимтэй өсч, хүн амын нягтаршил ихэсч, амьдралын нөхцөл өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор амны хөндийн өвчлөлийн тархалт нэмэгдсээр байна.

Зорилго: Улаанбаатар хотын хүн амын амны хөндийн зарим үзүүлэлтийг 5, 12, 35-44, 65-74 насны бүлгүүдэд судлах

Зорилт:

1. Судалгаанд хамрагдагсадын шүд цоорох өвчний тархалт, эрчмийн үзүүлэлтийг насны бүлгээр тодорхойлох
2. Судалгаанд хамрагдагсадын амны эрүүл ахуйн төлвийг үнэлэх


Арга аргачлал: Энэхүү судалгааг АШУҮИС-ийн НАСС-ийн ХНАСУС-ийн тэнхимийн төсөлт ажлын хүрээнд 2015-2016 онуудад хийгдсэн Улаанбаатар

хотын 6 дүүрэг (Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар)-ийн 5, 12, 35-44, 65-74 насны 1936 хүний амны хөндийн үзлэгийн картыг ашиглан, ретроспектив дескриптив судалгааны загвараар, АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн хяналтын хорооны зарчмуудыг баримтлан уг судалгааг хийж гүйцэтгэх 2020/3-04 тоот зөвшөөрлийн дагуу хийж гүйцэтгэлээ. Судалгааны үр дүнг статистикийн STATA Statistic version 12 программ хангамжийг ашиглан боловсруулсан.

Үр дүн: Судалгаанд 5 насны бүлгийн 503(25.9%), 12 насны бүлгийн 456(23.6%), 35-44 насны бүлгийн 492(25.5%), 65-74 насны бүлгийн 485(25.0%) тус тус хамрагдлаа.

Судалгаанд хамрагдагсадын ШЦӨ-ний тархалтыг насны бүлгээр судлан үзэхэд 5 насанд 90.9%, 12 насанд 81.4%, 35-44 насанд 98.2%, 65-74 насанд 99.8% тус тус байв (Зураг 1).

Доорх үр дүнгээс харахад нас нэмэгдэхийн хирээр ШЦӨ-ний тархалт насны бүлгүүдэд нэмэгдэж байгаа ерөнхий үр дүн ажиглагдаж байна. Харин 12 насны бүлэгт ШЦӨ-ний тархалт хамгийн бага байгаа нь энэ насанд сүүн шүд солигдож дуусан, байнгын шүднүүд шүдэлж, байнгын шүдний эгнээ төлөвшин, байнгын шүдний эгнээ хамгийн эрүүл байдаг гэсэн зүй тогтолтой дүйцэж байна.



Зураг 1. Шүд цоорох өвчний тархалт (насны бүлгээр)

ШЦӨ-ний эрчмийн үзүүлэлт нь ДЭМБ-ын шалгууураар үнэлэхэд 5 насанд 6.9±0.20 цла/ш буюу "өндөр" түвшинд, 12 насанд 2.5±0.10ЦЛА/ш буюу "бага" түвшинд, 35-44 насанд 12.1±0.30ЦЛА/ш буюу "дунд" түвшинд, 65-74 насанд 24.6±0.33ЦЛА/ш буюу "маш өндөр" түвшинд байлаа (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Шүд цоорох өвчний эрчмийн үзүүлэлт (насны бүлгээр)

Насны бүлэг	n	%	эрчим
5 нас	503	25.9	6.9±0.20 цла/ш
12 нас	456	23.6	2.5±0.10ЦЛА/ш
35-44 нас	492	25.5	12.1±0.30ЦЛА/ш
65-74 нас	485	25.0	24.6±0.33ЦЛА/ш
нийт	1936	100	

Амны эрүүл ахуйн төлөв нь насны бүлгүүдэд хангалттай үзүүлэлт нь харьцангуй ойролцоо байсан ба 65-74 насны бүлэгт хангалттай үзүүлэлт нь 74.4% буюу хамгийн өндөр гарсан нь амны эрүүл ахуйг тодорхойлох тухайн шүд байхгүй тохиолдол олон байсантай холбоотой юм.

Хүснэгт 2. Насны бүлгүүдийн амны эрүүл ахуйн төлөвийг судалсан дүн

Насны бүлэг	Амны эрүүл ахуйн төлөв				Нийт
	Хангалттай		Хангалтгүй		
	n	%	n	%	n
5 нас	264	52.5	239	47.5	503
12 нас	246	53.9	210	46.1	456
35-44 нас	267	54.3	225	45.7	492
65-74 нас	361	74.4	124	25.6	485

Хэлцэмж: Бидний судалгаагаар ШЦӨ-ний тархалт нь 5, 12, 35-44, 65-74 насны бүлгүүдэд 90.9%, 81.4%, 98.2% 99.8% ШЦӨ-ний эрчмийн үзүүлэлт сүүн зуултын үед 6.9±0.20 цла/ш, байнгын зуултын үед 2.5±0.10 ЦЛА/ш, 12.1±0.30 ЦЛА/ш, 24.6±0.33 ЦЛА/ш байлаа. Энэхүү үр дүнг бусад судлаачдын үр дүнтэй харьцуулахад Соарес нарын 2019 онд Өмнөд Америкт хийгдсэн судалгаагаар 5, 12, 35-44, 65-74 насны бүлгүүдэд ШЦӨ-ний эрчмийн үзүүлэлт 5.73 цла/ш, 3.14 ЦЛА/ш, 19.41 ЦЛА/ш, 28.19 ЦЛА/ш, Малави улсад 2016 онд судалгаагаар 12, 35-44, 65-74 насны бүлгүүдэд ШЦӨ-ний тархалт 19.1%, 49.0%, 49.2% байсан байна.[3,4] Олон Улсын Шүд Судлалын Холбооны Монгол дахь салбарын 2013 оны судалгааны үр дүнд манай орны 5, 12, 35-44, 65-74 насны бүлгүүдийн ШЦӨ-ний тархалт, эрчмийн үзүүлэлт 80.5%, 4.7 цла/ш, 64.82%, 1.51 ЦЛА/ш, 96.9%, 9.65 ЦЛА/ш, 98.8%, 19.87 ЦЛА/ш байсан[5] нь бидний судалгааны үр дүнтэй дүйцэж байна. Түүнчлэн бидний судалгааны үр дүнгээс өнгөрийн үзүүлэлт буюу амны эрүүл ахуйн төлөв өндөр хувьтай байгаа нь хүн амын дунд шүд амаа арчлах мэдлэг, дадал хангалтгүй байгааг харуулж байна. Иймд хүн амын дунд ШЦӨ-өөс урьдчилан сэргийлэх, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, шүд амаа арчлах аргыг өдөр тутмын амьдралын дадал хэвшил болгон тогтмолжуулах үйл ажиллагааг улам эрчимжүүлэн чанаржуулж, шаардлагатай байна.

Дүгнэлт: Судалгаанд 5 насны бүлэгт ШЦӨ-ний тархалт 90.9% байгаа нь 5 настай хүүхдийн дунд ШЦӨ-ний тархалт өндөр байгааг, 12 насны бүлэгт ШЦӨ-ний тархалт 81.4% буюу хамгийн бага байгаа нь энэ насанд сүүн шүд солигдож дуусан, байнгын шүднүүд шүдэлж, байнгын шүдний эгнээ төлөвшдөг үе учраас, 35-44 насны бүлэгт ШЦӨ-ний тархалт 98.2%, 65-74 насны бүлэгт ШЦӨ-ний тархалт 99.8% байгаа нь ШЦӨ-ний тархалт өндөр байгааг харуулж байна. 5 насны бүлэгт ШЦӨ-ний эрчмийн үзүүлэлт 6.9±0.20 цла/ш буюу "өндөр" түвшинд, 12 насны бүлэгт ШЦӨ-ний эрчмийн үзүүлэлт 2.5±0.10 ЦЛА/ш буюу "бага" түвшинд, 35-44 насны бүлэгт ШЦӨ-ний эрчмийн үзүүлэлт 12.1±0.30 ЦЛА/ш буюу "дунд" түвшинд, 65-74 насны бүлэгт ШЦӨ-ний эрчмийн үзүүлэлт 24.6±0.33 ЦЛА/ш буюу "маш өндөр" түвшинд байлаа. Амны эрүүл ахуйн төлөв 5 насанд 47.5% нь, 12 насанд 46.1%, 35-44 насанд 45.7%, 65-74 насанд 25.6% хангалтгүй үзүүлэлттэй байв.

Ном зүй:

1. *Kane SF. The effects of oral health on systemic health. Gen Dent. 2017;65(6):30-34.*
2. *https://www.fdiworlddental.org/oral-health/ask-the-dentist/facts-figures-and-stats. World Dental Federation Oral health Oral disease. 2020.*
3. *Soares GH, Pereira NF, Biazevic MGH, Braga MM, Michel-Crosato E. Dental caries in South American Indigenous peoples: A systematic review. Community dentistry and oral epidemiology. 2019;47(2):142-152.*
4. *Msyamboza KP, Phale E, Namalika JM, et al. Magnitude of dental caries, missing and filled teeth in Malawi: National Oral Health Survey. BMC Oral Health. 2016;16(1):1-6.*
5. *Хулан У, Баярчимэг Б. Монгол хүний амны хөндийн төлөв байдлыг судалсан үндэсний судалгааны дүн. 2013.*

The result of oral health survey Ulaanbaatar city

Bayarmaa.B[1], Oyuntsetseg.B[1]

[1]Department of Pediatric and Preventive Dentistry, School of Dentistry, MNUMS
Email: bayarmaa1725@gmail.com, Tel: 99088167

Dental caries is a worldwide spreader infectious decease. According to the present studies, the prevalence of the disease is highly dependent on the developmental of the country and its prevention strategies. By the World Dental Federation and World Health Organization (WHO) criteria, dental caries prevalence is increasing every year in Mongolia, which is becoming one of the main problems in our country. According to studies, the most effective method of decreasing prevalence of caries is to have an oral health knowledge, provide caries treatment on early-stage and focusing more on prevention. The studied population was 1936 subject who were selected from 4 age groups (5, 12, 35-44, 65-74 years old) and from 6 district of Ulaanbaatar. The prevalence of dental caries and mean Decayed, Missed, Filled permanent teeth (DMFt) / decayed, filled teeth (dft) were 90.9% and 6.9±0.20 among 5 years old, 81.4% and 2.5±0.10 among 12 years old, 98.2% and 12.1±0.30 among 35-44 years old, 99.8% and 24.6±0.33 among 65-74 years old. The poor oral hygiene index was 47.5%, 46.1%, 45.7% and 25.6%.

Key word: Oral health, Ulaanbaatar city